



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023. 01. 10 № 3Г-1/16
таний -ны № -т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

"Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000258



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20¹¹- он 11 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар X⁹⁷/2050

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн тесэл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

"Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Д.АМАРБАЯСГАЛАН




МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд:

"III.ХЭЛЭЛЦСЭН нь: Протокол соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: "Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Широндэвийн гудамж 8/4.
Чингалтай дүүргэ, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.09.12 № 1/4647
таний 2022.08.24 ны № 01/3853 -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



15160/359
Ая Файл: 2022



**МОНГОЛ УЛСЫН
ГАДЛАД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 36, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудас: Info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2022.08.31 № 09/4536
таний -ны № 09/3852 -т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.



Б.БАТЦЭЦЭГ

11522090



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингалтэй дүүрэг,
С.Данзандоржийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 28 74 88, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

дэлж. 09.15 № 01/6174
тавдай дэлж. 09.24-ны № 01/5855-т

Хариу хүргүүлэх тухай

Олон Улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн (а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762004846

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ.
ЗАМ. ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН САЙД

Л.ХАЛТАР

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН 50 ДУГААР
ЗҮЙЛИЙН А) ХЭСЭГТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛЫГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр үйлдсэн Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод Монгол Улс 1989 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улс болсон.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 122-т Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2021 онд батлахаар тусгасан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт "Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана" гэж заасны дагуу холбогдох протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах шаардлагатай.

1.2.Практик шаардлага

Канад Улсын Монреаль хотноо 2016 оны 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсан Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын 39 дүгээр Ассамблейн чуулганаар тус байгууллагын гишүүн орнууд "Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол"-ыг баталсан.

Конвенцын 50 дугаар зүйлд "ОУИНБ-ын Зөвлөл нь Ассамблейн өмнө ажлаа хариуцдаг байнгын байгууллага мөн. Зөвлөл нь Ассамблейгаас сонгогдсон гучин зургаан Хэлэлцэн тохирогч улсаас бүрдэнэ. Сонгуулийг Ассамблейн анхдугаар чуулган болон түүнээс хойш 3 жил тутамд явуулж тийнхүү сонгогдсон Зөвлөлийн гишүүд дараагийн сонгууль хүртэл үүрэг гүйцэтгэнэ" гэж заасан бөгөөд дээрх протоколоор Зөвлөлийн гишүүн улсын тоог гучин зургаа (36) байгааг 40 (дэч) болгон нэмэгдүүлэхээр тогтсон.

Монгол Улс ОУИНБ-ын бүрэн эрхт гишүүн болсноос хойш тус байгууллагаас баталсан бодлого, стандарт болон санал болгосон зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх, үл тохирлыг мэдээлэх, аюулгүй ажиллагааны өргөтгесэн аудитад

хамрагдах, жил бурийн гишүүнчлэлийн хураамж төлөх зэргээр "оролцогч" улсын байр суурийг хадгалж ирсэн.

Дээрх протоколд нэгдэн орж, Зөвлөлийн гишүүн улсын тоог 40 (деч) болгон нэмэгдүүлэх, ОУИНБ-ын бодлогыг дэмжих нь гишүүн улсын үүргээ биелүүлэх, тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, цаашид Ази, Номхон далайн бус нутгийг төлөөлж Зөвлөлийн гишүүнээр сонгогдох шаардлагатай. Зөвлөлийн гишүүнээр сонгогдох замаар олон улсын иргэний нисэхийн салбарт Монгол Улсын байр суурь, оролцоог нэмэгдүүлэх, агаарын тээврийн хөгжлийг дэмжих, ялангуяа Ази болон Европ, Хойд Америк, Африк тивийг холбосон агаарын дет зам бүхий газар нутгийн байршлын давуу талаа ашиглан бус нутгийн агаарын навигацийн үйлчилгээний түшиц газар болох бодлогыг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн теслийн өренхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн тесэл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана.

Гурав.Хуулийн тесэл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улс нь ОУИНБ-ын үйл ажиллагаанд оролцоогоо идэвхжүүлэхэд түлхэц болж, Зөвлөлийн тоог нэмэгдүүлэх санаачилгад өөрийн хувь нэмрийг оруулж, цаашид бодлого тодорхойлох түвшинд буюу Зөвлөлийн гишүүнээр сонгогдох томоохон зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох юм. Протоколыг соёрхон батлах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалтай тус тус нийцнэ.

Хуулийн тесэл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа серег үр дагавар гарахгүй, улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Дөрөв.Хуулийн тесэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн тесэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

АНУ-ын Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр баталсан "Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц" 1947 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс хучин төгөлдөр болж, Монгол Улс тус конвенцэд 1989 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр нэгдэн орж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улс болсоноор тус байгууллагын бодлого, чиглэлийн дагуу олон улсын стандарт, шаардлагад нийцсэн иргэний нисэхийн тогтолцоо бүрдүүлэх, салбарыг хөгжүүлэх, дэлхийн агаарын харилцаанд бусад гишүүн улс орны адил эрх тэгш оролцох боломж бүрдсэн.

Канад Улсын Монреаль хотноо 2016 онд зохион байгуулсан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ассамблейн 39 дэх чуулганаар "Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах протокол"-ыг баталсан.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлд "Зөвлөл нь Ассамблейд ажлаа тайлагнадаг байнгын байгууллага мөн. Зөвлөл нь Ассамблейгаас сонгогдсон Хэлэлцэн тохиролцогч 36 улсаас бүрдэнэ. Сонгуулийг Ассамблейн анхдугаар чуулганаар зохион байгуулах бөгөөд түүнээс хойш 3 жил тутамд явагдаж, тийнхүү сонгогдсон Зөвлөлийн гишүүд дараагийн зэлжит сонгууль хүртэл үүргээ гүйцэтгэнэ" гэж заасан бөгөөд 2016 оны Протоколоор Зөвлөлийн гишүүдийн тоо 36 байгааг 40 болгон нэмэгдүүлэхээр тогтсон.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөл нь тус байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангах буюу олон улсын иргэний нисэхэд мөрдөгдхөх стандарт, санал болгосон зөвлөмж (SARP)-ийг баталж, Чикагогийн конвенцын Хавсралт болгон мөрдүүлэх, байгууллагын санхүүг захиран зарцуулах, Агаарын тээврийн хороо, Агаарын навигацийн үйлчилгээний хороо, Санхүүгийн хороо, Хууль бус үйл ажиллагааны хороо, Техникийн хамтын ажиллагааны хороо, Хүний нөөцийн хороо, Агаарын навигацийн комиссын гишүүдийг томилох болон гишүүн орнуудын хооронд Чикагогийн конвенцын хэрэгжилттэй холбоотой үүссэн маргаанд арбитрын шүүхийн үүрэг гүйцэтгэдэг байна.

Зөвлөлийн гишүүн улсыг сонгохдоо:

- I бүлэг. Агаарын тээвэрт тэргүүлэх ач холбогдолтой орнууд;
- II бүлэг. Олон улсын иргэний агаарын навигацийн байгууламжаар хангахад хамгийн их хувь нэмэр оруулж байгаа 1-р бүлэгт ороогүй улсууд;
- III бүлэг. Зөвлөлийн 1 болон 2 дугаар бүлэгт багтаагүй бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнд байснаар газар зүйн чухал бус нутгийн төлөөллийг бий болгох гишүүн улс гэсэн шалгуураар тус тус сонгон бүрдүүлдэг.

Канад Улсын Монреаль хотноо 2019 онд зохион байгуулсан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 40 дэх удаагийн Ассамблейн чуулганаар I бүлэгт Австрали, АНУ, Бразил, Канад, БНХАУ, Франц, Герман, Итали, Япон, ОХУ, Их Британи, II бүлэгт Аргентин, Колумб, Египет, Финлянд, Энэтхэг, Мексик, Нидерланд, Нигер, Саудын Араб, Сингапур, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Испани, III бүлэгт Коста Рика, Кот-д'Ивуар, Доминикан, Эквадорын Гвиней, Грек, Малайз, Парагвай, Перу, Бүгд Найрамдах Солонгос Улс, Судан, Тунис, Арабын Нэгдсэн Эмират Улс, Замби улсууд Зөвлөлийн гишүүнээр тус тус сонгогдоод байна.

Агаарын тээврийн зорчигч урсгалын дэд бус болон зангилаа төвүүд Олон улсын иргэний нисэхийн байгууллагад төлөөлөлгүй байгаа тул гишүүн улсын

төлөөллийг зохиуст хэмжээнд хүргэх, түүнчлэн дэлхийн олон бүс нутагт шинээр байгуулж байгаа болон хүчин чадлыг нь нэмэгдүүлж буй нисэх буудлуудад агаарын навигацийн үйлчилгээний хэрэгцээ шаардлага ессөн зэрэг хүчин зүйлийг харгалзан Зөвлөлийн гишүүн улсын тоог нэмэгдүүлэх шаардлага бий болсон.

Цар тахлаас өмнө буюу 2019 онд олон улсын агаарын тээврээр зорчигчдын тоо 4.5 тэрбум болсон нь 2018 оныхос 3.6 хувиар ессөн үзүүлэлттэй байсан.

Монгол Улсын хувьд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн болсон 1989 оны байдлаар 3 улс буюу Зөвлөлт Холбоот Улс (ОХУ), БНХАУ, Польш Улстай агаарын харилцаа тогтоож, олон улсын 3 чиглэлд нислэг гүйцэтгэж байсан бөгөөд 1990 оноос хойш 39 улстай хоёр талт Агаарын харилцааны хэлэлцээр байгуулж, агаарын тээврийн зорчигч урсгал 1993 онд 227.9 мянга байсан бол 2019 онд 1.6 сая зорчигч болж, дотоодын 4, гадаадын 7 агаарын тээвэрлэгч олон улсын 17 чиглэлд хуваарьт нислэг үйлдэж байна.

Чикагогийн конвенц хүчин төгөлдөр болсон 1947 онд Олон улсын иргэний нисэхийн байгууллага нь нийт 26 гишүүнтэй байсан. Зөвлөлийн тухайд 1961, 1971, 1974, 1990 онд конвенцэд оруулсан 4 удаагийн өөрчлөлтөөр 21-ээс 36 болж нэмэгдсэн бөгөөд Зөвлөлийн гишүүн 1990 онд 36 улс болгон нэмэгдүүлэх үед 163 гишүүнтэй болсон. Үүнээс хойш агаарын тээвэр нь дэлхийн улс орны эдийн засгийн хөгжил, аялал жуулчлалын хөгжлийн гол хүчин зүйл болж, технологийн дэвшил, хурдацтай өөрчлөгдөж буй арилжааны агаарын тээврийн стратегийг харгалзан Ази, Номхон далай, Африкийн бүс нутгийн хөгжиж буй орнууд Зөвлөлд төлөөллөө нэмэгдүүлэх эрмэлзэл өссөн байна.

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүний хувьд тус байгууллагын бодлого, стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, үл тохирлыг мэдээлэх, аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудитад хамрагдах, гишүүнчлэлийн хураамж төлөх зэргээр "оролцогч" улсын байр суурийг хадгалж байна.

Монгол Улс бодлого тодорхойлох түвшинд оролцох, Зөвлөлийн бүрэлдэхүүнд Ази тивээс орсон 6 улсын төлөөллийг өргөтгөх санаачилгад өөрийн орны хувь нэмрийг оруулж, ирээдүйд Зөвлөлийн гишүүнээр сонгогдох үйл хэрэгт түлхэц болгох зорилгоор "Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах протокол"-ыг соёрхон батлах нь зүйтэй байна.

Дэлхийн агаарын тээврийн тэргүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дунд байрлалтай манай улсын нутаг дэвсгэр дээгүүр Ази, Европ тивийг холбосон хамгийн дэт агаарын зам дамжин өнгөрч байна.

Далайд гарцгүй манай орны хувьд агаарын тээвэр нь гуравдагч оронтой богино хугацаанд шууд холбогдох онц чухал ач холбогдолтой салбар бөгөөд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор бүс нутгийн агаарын навигацийн гол түшиц орон зайд болох, олон улсын нисэх буудлын ашиглалтыг сайжруулах, агаарын тээвэр өргөжин хөгжихэд ач холбогдолтой юм.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 94 дүгээр зүйлд зааснаар конвенцэд оруулсан аливаа өөрчлөлт нийт гишүүн орнуудын гуравны хоёр нь соёрхон баталсан тохиолдолд хүчин төгөлдөр болно. Түүнчлэн дээрх Протоколын 3 дугаар зүйлийн 3 (d) хэсэгт зааснаар уг протокол хүчин төгөлдөр болоход нийт 128 гишүүн орон соёрхон баталсан байх шаардлагатай бөгөөд одоогоор 60 орон нэгдэж, соёрхон баталсан тухай батламжийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлээд байна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах Протоколд нэгдэн орох тухай асуудлыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ний өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Канад Улсын Монреаль хотод 2016 оны 10 дугаар сарын 6-ны өдөр баталсан "Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН 50 ДУГААР
ЗҮЙЛИЙН А) ХЭСЭГТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ**

Монреаль хотноо 2016 оны 10 дугаар сарын 06-нд гарын үсэг зурав

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН АССАМБЛЕЙ,

Монреаль хотноо 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдөр өөрийн гучин есдүгээр чуулганд ЦУГЛАРЧ,

Хэлэлцэн тохиролцогч улсуудын төлөөллийг өргөтгөх замаар тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор Зөвлөлийн гишүүдийн тоог нэмэх талаар Хэлэлцэн тохиролцогч олон улсуудын илэрхийлсэн хүснэгтийг ТЭМДЭГЛЭЖ,

Энэ байгууллагын гишүүдийн тоог гучин зургаагаас деч болгон нэмэгдүүлэхийг зохих ёсоор ХАРГАЛЗАН ҮЗЭЖ;

Дээр дурдсан зорилгоор Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг ХАРГАЛЗАН ҮЗЭЖ;

1. Энэхүү Конвенцын 94 дүгээр зүйлийн а) хэсэгт заасны дагуу Конвенцод дараах санал болгосон өөрчлөлтийг оруулахаар БАТЛАВ:

Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсгийн хоёрдугаар өгүүлбэрт заасан "гучин зургаа" гэснийг "деч" гэж;

2. Энэхүү Конвенцын 94 дүгээр зүйлийн а) хэсэгт заасны дагуу дээр дурдсан өөрчлөлт Хэлэлцэн тохиролцогч нэг зуун хорин найман улс соёрхон баталснаар хучин төгөлдөр болохыг ТОГТООВ;

3. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга дээрх нэмэлт, өөрчлөлт болон дор дурдсан нехцелийг тусгасан протоколын эх бичвэрийг англи, араб, хятад, франц, орос, испани хэлээр үйлдэх бөгөөд эх бичвэр бүр адил хүчинтэй байхаар ШИЙДВЭРЛЭВ:

a) Протоколд Ассамблейн Дарга болон Ерөнхий Нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

b) Протокол нь дээр дурдсан Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенциг соёрхон баталсан эсхүл, нэгдэн орсон аливаа улс соёрхон замын батлахад нээлттэй байна.

c) Батламж жуух бичгийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хадгалуулна.

ALBAN ECHNY ORCHUULGA MON

2016 оны 10 сарын 20 өдөр
Уланбаатар хот

- d) Протокол нь соёрхон баталсан тухай нэг зуун хорин найм дахь Батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс эхлэн түүнийг соёрхон баталсан улсуудын хувьд хүчин төгөлдөр болно.
- e) Ерөнхий нарийн бичгийн дарга протоколыг соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг бүрийн хадгалуулсан огноог Хэлэлцэн тохиролцогч улс бүрт нэн даруй мэдэгдэнэ.
- f) Ерөнхий нарийн бичгийн дарга протоколын хүчин төгөлдөр болсон огноог дурдсан Конвенцын Хэлэлцэн тохиролцогч улсуудад нэн даруй мэдэгдэнэ.
- g) Дээр дурдсан огнооноос хойш уг протоколыг соёрхон баталсан Хэлэлцэн тохиролцогч аль ч улсын хувьд Олон улсын иргэний нисэхийн байгууллагад соёрхон баталсан вэрийн Батламж жуух бичгээ хадгалуулснаар хүчин төгөлдөр болно.

ҮҮНИЙ ҮР ДҮНД, Ассамблейн дээр дурдсан үйл ажиллагааны дагуу,

Энэхүү протоколыг тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга үйлдэв.

ҮҮНИЙГ НОТОЛЖ, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ассамблейн гучин есдүгээр чуулганаас олгосон эрхийн дагуу уг Ассамблейн Дарга болон Ерөнхий нарийн бичгийн дарга нар энэхүү протоколд гарын үсэг зурав.

Монреаль хотноо хоёр мянга арван зургаан оны аравдугаар сарын зургааны өдөр англи, араб, хятад, франц, орос, испани хэлээр нэгэн баримт бичиг болгон үйлдсэн бөгөөд эх бичвэр бүр нь нэгэн адил хүчинтэй байна. Энэхүү протокол нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын архивт хадгалагдах бөгөөд тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг баталсан хувийг Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын Хэлэлцэн тохиролцогч бүх улсуудад илгээнэ.

А.АБДУЛ РАХМАН

Ф.ЛИУ

АССАМБЛЕЙН ГУЧИН
ЕСДҮГЭЭР ЧУУЛГАНЫ ДАРГА

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Монгол Улсын Гадаад харилцааны нам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МОНГ

Гарын үсэг - Signature
2021 оны 10 сарын 20 өдөр
Улсын Гадаад харилцааны нам
CL.

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг зөвшилцэх.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг хэлэлцэн дэмжин.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

БАЙНГЫН ХОРОО
ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ



Б.БАТТӨМӨР

Б.ГАНДИЙМАА

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН 50 ДУГААР
ЗҮЙЛИЙН А) ХЭСЭГТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛД
НЭГДЭН ОРОХ ТУХАЙ САНАЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДУГНЭЛТ**

2022 оны 03 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зөвшилцэхеер Улсын Их Хуралд ирүүлсэн Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ хэлэлцэж буй асуудлыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, сүүлийн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан иргэний нисэхийн навигацийн орлого буурч байгаатай холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай, Өмнөговь аймагт олон улсын нисах буудал байгуулах асуудлыг Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс дэмжиж байгаа эсэхийг асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс уг хэлээгүй болно.

Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколд нэгдэн орох тухай саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжив.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БАТТӨМӨР

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН
50 ДУГААР ЗҮЙЛИЙН а/ХЭСЭГТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

1. Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Мөнхтуяа – 99113244;
2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Мөнхнасан – 99114468

--- о О о ---